



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хороотой зөвшилцөлгүйгээр болон уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулалгүйгээр харьяалж байсан байгууллагын хамаарал бүхий этгээдүүдэд хувьчилсан нь хувьчлалыг хүчингүй болгох үндэслэл болж байна.



Арцат зуслан



Гүннуур зуслан

АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД: СЭА-2023/29-17-НА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Утас: 70363040	Б.Батмөнх
2023 он	Аудитын менежер	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Утас: 70363036	Ц.Отгонбаяр
	Ахлах аудитор	Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Утас: 70363036	Ж.Цогт
	Аудитор	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
	Утас: 70363036	

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Ерөнхий мэдээлэл	3
1 дүгээр бүлэг: Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан нь хувьчлалыг хүчингүй болгох үндэслэл болж байна.	4
1.1 Хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг “Удирдлагын гэрээ”-гээр бус “Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах арга”-ын “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлсэн нь УИХ, Засгийн газар, аймгийн ИТХТ-ийн шийдвэрүүдийг зөрчсөн байна.	4
1.2 Мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн хүүхдийн зуслангуудыг хувьчлах, худалдах доод үнийг тогтоосон байна.	6
1.3 Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан байна.	7
2 дугаар бүлэг: Хүүхдийн зуслангуудыг удирдах уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулаагүй нь хувьчлалыг хүчингүй болгох үндэслэл болж байна.	8
2.1. Уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу нээлттэй зохион байгуулаагүй байна.	8
2.2 Хүүхдийн зуслангийн барилгын зах зээлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.	10
3 дугаар бүлэг: Хүүхдийн зуслангуудыг хувьчилсан шийдвэр болон “Худалдах, худалдан авах гэрээ”-ний биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцоогүй байна.	12
3.1 “Менежментийн гэрээ” болон “Худалдах, худалдан авах гэрээ”-ний оролцогч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	12
3.2 Хүүхдийн зуслангийн удирдлагуудтай байгуулсан гэрээний биелэлтэд тухай бүр хяналт хэрэгжүүлээгүй байна.	14
Дүгнэлт	15
Зөвлөмж	16
Ирүүлсэн санал, тайлбар	17
Төрийн аудитын газрын тайлбар	18

Товчилсон үгийн жагсаалт

ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УИХ	Улсын Их Хурал
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөрөнгийн үнэлгээ	6
Хүснэгт 2	Мон үнэлгээ ХХК-ийн тогтоосон үнэлгээ	11
Хүснэгт 3	ИТХТ-ийн тогтоол	11
Хүснэгт 4	Зуслангийн хувьчлалын төлбөр	11
Хүснэгт 5	Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тулгалт	14

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2023 оны А/02 дугаар тушаалаар баталж, А/67 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд хийх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн нэгдсэн удирдамжаар гүйцэтгэв.
Аудитын зорилт:	Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд нийцлийн аудит хийн дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэв. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.Үүнд: ➤ Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх, ➤ Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх, ➤ Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцсон эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Тус аудитад аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа хүүхдийн зуслангийн хувьчлалын асуудалд хамаарах төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хамруулж, холбогдох шийдвэр, архивын баримт, материалд үндэслэн дүгнэлт гаргалаа. Мөн орон нутгийн өмчит хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэн, хуулийн этгээдээс асуулга, тодруулга мэдээлэл авч, хувьчлалтай холбоотой шийдвэр, гэрээний оролцогч талуудын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх байдлаар аудитад хамруулав.

Аудитын арга зүй:	Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” болон МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ. Аудитаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд шинжилгээ хийх, шалгагдагч болон хамрагдагч байгууллага, иргэдээс асуулга, лавлагаа, тайлбар авах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, хувьчлагдсан зуслангуудын газар дээр нь очиж танилцах зэргээр нотлох зүйлс цуглуулж, үр дүнг нягтлан шалгаж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлтийг боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа.Үүнд: • Төрийн аудитын тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он), • БНМАУ-ын Өмч хувьчлах тухай хууль (1991 он), • Монгол Улсын Их Хурлын 2002 оны “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай” 56 дугаар тогтоол, • Засгийн газрын 2003 оны “Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагуудын жагсаалт батлах тухай” 34 дүгээр тогтоол, • Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2003 оны 57 дугаар тогтоол, • Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль, эрхийн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Ж.Цогт нар 2023 оны 09 дүгээр сарын 10-аас 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	УИХ-ын 2002 оны 56, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолууд, аймгийн ИТХТ-ийн 2003 оны 57, 2011 оны 90 дүгээр тогтоолуудыг үндэслэн доорх гэрээнүүдийг байгуулан ажилласан байна. Үүнд: • 2003 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Хэрх тосгоны сургуулийн харьяа Арцат, аймгийн Хүүхдийн төлөө төвийн харьяа Гүннуур хүүхдийн зуслангуудыг хувьчлагдаж дуустал “Аж ахуйн тооцоон дээр ажиллуулах гэрээ”, • 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүүхдийн зуслангуудыг “Менежментийн гэрээ”-гээр 2007 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаатай ажиллуулах гэрээ, • 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Худалдах худалдан авах гэрээ”-гээр Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг худалдаж, уг гэрээ нь 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл хүчинтэй байхаар тусгасан.

**Бүлэг
1**

**Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох
хууль, тогтоомжид нийцсэн эсэх.**

Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан нь хувьчлалыг хүчингүй болгох үндэслэл болж байна.

**1.1 Төрийн өмчийн хөрөнгийг хувьчлахдаа хувьчлалын арга хэлбэрийг
хууль, журмын дагуу сонгосон эсэх**

Хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг “Удирдлагын гэрээ”-гээр бус “Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах арга”-ын “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлсэн нь УИХ, Засгийн газар, аймгийн ИТХТ-ийн шийдвэрүүдийг зөрчсөн байна.

1.1.1 УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан “*Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл*”-ийн 1 дүгээр зүйлийн 1.5-д “..*Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийхэд дараах төрийн өмчийн байгууллага, тусламж, үйлчилгээ хамрагдана. 1.5.3.3: “хүүхдийн ордон, зуслан”, 2 дугаар зүйл: “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх хүрээнд авах арга хэмжээ, 2.3.1.6: “аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр орон нутгийн чанартай асрамжийн газар, хүүхдийн зуслан,...-ын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх”* гэж,

1.1.2 Засгийн газрын 2003 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “2003 онд нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагуудын жагсаалт батлах тухай” 34 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад “*Орон нутгийн амралт, сувилал, хүүхдийн зуслан...г Төрийн өмчийн хороо, ..Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай зөвшилцөн, удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлж эхлэх*” гэж тус тус заасан байна.

1.1.3 Дээрх шийдвэрүүдийг үндэслэн аймгийн ИТХТ нь 2003 оны 08 дугаар сарын 04-ний өдөр “ Гэрээгээр гүйцэтгүүлэх тухай “ 57 дугаар тогтоол гаргасан байна.

1.1.4 Аймгийн ИТХТ-ийн дээрх 57 дугаар тогтоол гарахаас өмнө 2003 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Хэрх тосгоны сургуулийн харьяа Арцат, аймгийн Хүүхдийн төлөө төвийн харьяа Гүннуур хүүхдийн зуслангуудыг хувьчлагдаж дуустал “**Аж ахуйн тооцоон дээр ажиллуулах гэрээ**”-г тухайн үеийн Хэрх тосгоны сургуулийн захирал Г.Жаргалтулга, аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга Д.Уранбилэг нартай тус тус байгуулан, ажиллуулж байсан байна.

1.1.5 Аймгийн ИТХТ-ийн 57 дугаар тогтоолыг үндэслэн гаргасан Аймгийн Засаг даргын 2004 оны 353 дугаар захирамжаар байгуулагдсан “*Тендерийн комисс*” нь уралдаант шалгаруулалт явуулж, шалгаруулсан гэх үндэслэлээр 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр тухайн үеийн Хэрх тосгоны сургуулийн захирал асан Г.Жаргалтулгын төрсөн хүүхэд Ж.Эрдэнэтөгстэй Арцат зусланг, аймгийн Хүүхдийн

төлөө төвийн дарга Д.Уранбилэгтэй Гүннуур хүүхдийн зусланг тус тус удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулахаар гэрээ байгуулсан байна.

1.1.6 Менежментийн баг нь “Менежментийн гэрээ”-г амжилттай дүгнүүлсэн гэх үндэслэлээр 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Худалдах худалдан авах гэрээ” байгуулж, Арцат хүүхдийн зусланг Л.Пүрэвдулам /Ж.Эрдэнэтөгсийн ээж/-д, Гүннуур хүүхдийн зусланг Д.Уранчимэг /Д.Уранбилэгийн төрсөн дүү/-т тус тус худалдсан байна.

1.1.7 Өөрөөр хэлбэл орон нутгийн өмчийн хүүхдийн зуслангуудыг:

- 2003 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс “Аж ахуйн тооцоон дээр ажиллуулах гэрээ”-гээр,
- 2004 оны 11 сарын 02-ны өдрөөс удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын төсөл сонгон шалгаруулсан гэх үндэслэлээр “Менежментийн гэрээ” -гээр,
- 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулж байгаа багт нь давуу эрхээр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж худалдсан байна.

1.1.8 Хүүхдийн зуслангийн удирдлагын үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх явцад дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- 2003.06.09-ний өдрөөс 2004.11.02 -ны өдрийг хүртэл “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл” болон Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолд тусгагдаагүй “Аж ахуйн тооцоон дээр ажиллуулах гэрээ”-г зуслангуудыг харьяалж байсан байгууллагын дарга болох Хэрх тосгоны сургуулийн захирал Г.Жаргалтулга, аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга Д.Уранбилэг нартай сонгон шалгаруулалтгүйгээр байгуулж, ажиллуулсан,
- УИХ-ын 2002 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 56, Засгийн газрын 2003 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 34, аймгийн ИТХТ-ийн 2003 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 57 дугаар тогтоолуудаар хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг нь “Удирдлагын гэрээ”-гээр гүйцэтгүүлэхээр тус тус заасан байдаг. Гэтэл Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Комисс томилох тухай” 353 дугаар захирамжаар “Хүүхдийн Гүннуур, Арцат зуслангуудын үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын төсөл сонгон шалгаруулах тендерийн комисс”-ыг байгуулсан боловч төсөл сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаагүй байна. Мөн Төрийн өмчийн хороо, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яамтай зөвшилцөөгүй атал “Хүүхдийн зусланг менежментийн гэрээгээр ажиллуулах гэрээ”-г 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр тухайн үеийн Хэрх тосгоны сургуулийн захирал Г.Жаргалтулгын төрсөн хүүхэд Ж.Эрдэнэтөгстэй байгуулж Арцат зусланг, аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга Д.Уранбилэгтэй байгуулж Гүннуур зусланг тус тус удирдуулсан байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг “Удирдлагын гэрээ”-гээр бус удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын төсөл сонгон шалгаруулах замаар буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйл “Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах арга”-ын 58.3-д заасан 3 жилийн хугацаатай “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлсэн нь УИХ, Засгийн газар, аймгийн ИТХТ-ийн шийдвэрүүдийг зөрчсөн байна.

- 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан “Менежментийн гэрээ”-нд заасанчлан гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнээгүй, санхүүгийн тайланд аудит хийлгээгүй, хугацаа дууссан гэрээг сунгаагүй, Төрийн өмчийн хороотой зөвшилцөөгүй атал гэрээний хүчинтэй хугацаа дууссанаас хойш 3 жилийн дараа / 2011.01.11-ний өдөр/ менежментийн багт буюу хүүхдийн зусланг харьяалж байсан байгууллагын дарга, удирдлагуудын хамаарал бүхий этгээдүүдэд давуу эрхээр худалдсан гэх мэт.

1.2 Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг хууль, журамд заасны дагуу тогтоосон эсэх

Мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн хүүхдийн зуслангуудыг хувьчлах, худалдах доод үнийг тогтоосон байна.

1.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтооно”, 37.3-т “Худалдах доод үнэ тогтоох журмыг Засгийн газар батална” гэж заасан байдаг.

1.2.2 Дээрх заалтын дагуу Засгийн газрын 2001 оны 84 дүгээр тогтоолоор “Худалдах доод үнэ тогтоох журам”-ыг баталсан байна.

1.2.3 2010 онд батлагдсан “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Үйлчлүүлэгч болон үнэлгээчин харилцан тохиролцсон бол хөрөнгийн үнэлгээг гэрээний үндсэн дээр хийнэ” гэсэн заалтын дагуу аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн захиалгаар хүүхдийн зуслангуудын хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага болох “Мон үнэлгээ ХХК”-иар гүйцэтгүүлсэн байна.

1.2.4 Мон үнэлгээ ХХК-ийн хийж гүйцэтгэсэн хөрөнгийн үнэлгээний тайланд 2010 оны 6 дугаар сарын байдлаар Арцат зуслангийн 44 ширхэг барилгыг 35,580.0 мянган төгрөгөөр, Гүннуур зуслангийн 41 ширхэг барилгын зах зээлийн өнөөгийн үнэ цэнийг 49,140.0 мянган төгрөгөөр тус тус үнэлсэн байна.

1.2.5 Мон үнэлгээ ХХК-ийн хөрөнгийн / байшин, барилгын / үнэлгээний тайлан, бусад бараа материал, эргэлтийн хөрөнгийн бүртгэлийн үнийг тооцон аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоолоор Арцат зусланг 47,531.8 мянган төгрөгөөр Гүннуур зусланг 58,056.4 мянган төгрөгөөр тус тус худалдах доод үнийг тогтоосон байна.

Хүснэгт 1: Хөрөнгийн үнэлгээ /мянган төгрөгөөр/

№	Зуслангийн нэр	Мон үнэлгээ ХХК-ийн тогтоосон үнэ	Бусад хөрөнгө	ИТХТ-ийн шийдвэр
1	Арцат зуслан	35,580.0	11,951.8	47,531.8
2	Гүннуур зуслан	49,140.0	8,916.4	58,056.4

Эх сурвалж: Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоол

1.2.6 Аймгийн ИТХТ нь дээрх тогтоолоор Арцат, Гүннуур зусланг “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулж байгаа багт давуу эрхээр худалдахыг, давуу эрхээр худалдан авахгүй тохиолдолд мөн үнээр нийтийн дуудлага худалдаанд оруулахаар шийдвэрлэсэн байна.

1.3 Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх

Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан байна.

1.3.1 Аймгийн ИТХТ-ийн 2003 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд “Гүннуур, Арцат хүүхдийн зусланг удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэхээр тогтоосугай” гэж заасан нь хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг нь “Удирдлагын гэрээ”-гээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн УИХ-ын 2002 оны 56 дугаар, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолуудтай тус тус нийцэж байна.

1.3.2 Харин Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “ Комисс томилох тухай” 353 дугаар захирамжийн 1 дүгээрт “Хүүхдийн Гүннуур, Арцат зуслангуудын үйл ажиллагааг **удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын** төсөл сонгон шалгаруулах тендерийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай” гэж заасан байна.

1.3.3 Төсөл сонгон шалгаруулах замаар хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйл “ Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах арга”-ын 58.3-д заасан 3 жилийн хугацаатай “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн нь УИХ-ын 2002 оны 56, Засгийн газрын 2003 оны 34, аймгийн ИТХТ-ийн 2003 оны 57 дугаар тогтоолуудтай зөрчилдөж байна.

1.3.4. Өөрөөр хэлбэл аймгийн Засаг даргын 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 353 дугаар захирамжид нэг талаас “Удирдлагын гэрээгээр удирдах” гэж заасан ч нөгөө талаас “Менежментийн хувьчлалын” төсөл сонгон шалгаруулах тендерийн комисс байгуулж, 3 жилийн хугацаа / 2007 оны 11 сарын 04-ний өдөр хүртэл/- тай “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулахаар шийдвэрлэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан “Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах” аргаар хувьчилсан мэт ойлгогдож, шийдвэрийн утга санаа нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

1.3.5 Сонгон шалгаруулалт явуулсан /сонгон шалгаруулалтын баримтууд байхгүй/ гэх үндэслэлээр байгуулсан “Менежментийн гэрээ”-г жил бүр дүгнэх, зуслангийн тайланд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэхээр тусгасан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.3.6 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан дээрх “Менежментийн гэрээ”-ний хүчинтэй хугацаа нь 2007 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр дуусаж, хугацааг сунгаагүй байхад аймгийн Засаг даргын 2010 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 106 дүгээр захирамжаар байгуулагдсан “Менежментийн гэрээний биелэлтийг үнэлэх ажлын хэсэг” нь “Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн гэж үзээд зуслангуудыг менежментийн багт хувьчлан өгөх боломжтой” гэж дүгнэсэн байна.

1.3.7 Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулж байгаа багт нь давуу эрхээр худалдах, үйл ажиллагааны чиглэлийг 5 жилийн хугацаанд өөрчлөхгүй байх шаардлага бүхий гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байна.

1.3.8 Аймгийн ИТХТ нь хүүхдийн зуслангуудыг менежментийн багт нь давуу эрхээр худалдах шийдвэр гаргахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь “... хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.3.9 Аймгийн ИТХТ-ийн дээрх шийдвэрийн дагуу 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Арцат хүүхдийн зусланг Л.Пүрэвдулам /Ж.Эрдэнэтөгсийн ээж/-д, Гүннуур хүүхдийн зусланг Д.Уранчимэг /Д.Уранбилэгийн төрсөн дүү/-т тус тус худалдахаар “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж, аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбат баталсан байна.

1.3.10 Дээр дурдсанаар аймгийн ИТХТ нь орон нутгийн өмчийн Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйл: “Хувьчлалыг хүчингүйд тооцох үндэслэл”, 62.2 дахь “Тодорхой объектыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүй хувьчилсан” гэсэн заалтын дагуу хувьчлалыг хүчингүй болох үндэслэл болж байна.

Бүлэг II

Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх?

Хүүхдийн зуслангуудыг удирдах уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулаагүй нь хувьчлалыг хүчингүй болгох үндэслэл болж байна.

2.1 Сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх?

Уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу нээлттэй зохион байгуулаагүй байна.

2.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65¹ дүгээр зүйлийн 65^{1.3}-т “Нийгмийн салбарын хувьчлалд энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасан хувьчлалын аргуудыг нэгэн адил хэрэглэж болно”, 65² дугаар зүйлийн 65^{2.2}-т “Удирдлагын гэрээгээр ажиллуулах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулна”, гэж заасан буюу хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулах уралдаант шалгаруулалтыг тус хуулийн 46-54 дүгээр зүйлийн дагуу зохион байгуулахаар зохицуулагдсан байдаг.

2.1.2 Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар “Хүүхдийн зусланг удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх төсөл сонгон шалгаруулах журам”-ыг баталсан бол Засаг даргын 2004 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 353 дугаар захирамжаар “Хүүхдийн Гүннуур, Арцат зуслангуудын үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр удирдах менежментийн хувьчлалын төсөл сонгон шалгаруулах тендерийн комисс”-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

2.1.3 Аймгийн ИТХТ, Засаг даргын дээрх шийдвэрүүдээр хүүхдийн зуслангуудын удирдлагын үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр удирдах этгээдийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулахаар журамлаж, комиссын бүрэлдэхүүнийг томилсон хэдий ч уралдаант шалгаруулалтын зар мэдээ, оролцогчдод тавих шаардлага, эрх үүрэг, төслийг хүлээн авах, нээх, дүгнэх журам зэргийг тусгасан тендерийн баримт бичиг, тендер хүлээн авсан, дүгнэсэн материалууд байхгүй буюу уралдаант шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулаагүй байна.

2.1.4 Уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасны дагуу нээлттэй зохион байгуулаагүй атал хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлж байгаад аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоолоор “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулж байгаа багт нь давуу эрхээр худалдахаар шийдвэрлэж, 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан байна.

2.1.5 Өөрөөр хэлбэл 2004 онд Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу нээлттэй зохион байгуулаагүй атал “Менежментийн гэрээ”-ний үндсэн дээр гүйцэтгүүлж, улмаар 2011 онд менежментийн багт давуу эрхээр худалдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1: “Дараах үндэслэлийн аль нэг нь байвал хувьчлалыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно”, 62.3 дахь “дуудлага худалдааны болон уралдаант шалгаруулалтын журам зөрчсөн” гэсэн заалтын дагуу Арцат, Гүннуур зуслангийн хувьчлалыг хүчингүй болох нөхцөлийг үүсгэсэн байна.

2.1.6 Мөн хүүхдийн зуслангуудыг удирдлагын гэрээгээр ажиллуулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, гэрээ байгуулах, дүгнэх ажиллагааг Төрийн өмчийн хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран гүйцэтгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65² дугаар зүйлийн 65².3-т “Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулах, гэрээг дүгнэх ажлыг Төрийн өмчийн хороо, тухайн хуулийн этгээдийг харьяалах салбарын төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Хүүхдийн зусланг хувьчлахдаа зах зээлийн үнэлгээг бодитоор тооцож, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх?

Хүүхдийн зуслангийн барилгын зах зээлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

2.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д *“Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахын өмнө хувьчлах эд хөрөнгийг энэ хуулийн 37, 70 дугаар зүйлд заасны дагуу тооллого, үнэлгээ хийж, Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтад шилжүүлнэ”, 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтооно.”* гэж тус тус заасан байна.

2.2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1¹, 70.4²-д заасны дагуу дотоодын үндсэн хөрөнгийн тооллогыг зуслангийн удирдлагууд жил бүрийн эцэст, улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн хорооны удирдлага дор Орон нутгийн өмчийн газар 2008 онд зохион байгуулсан гэх боловч Гүннуур зуслангийн 2008 оны улсын үзлэгийн баримтаас бусад тооллогын баримтуудыг архивын нэгж болгон хадгалаагүй байна.

2.2.3 Арцат, Гүннуур зуслангийн удирдлагуудтай 2004 онд байгуулсан *“Менежментийн гэрээ”*-ний 2.1-д *“Аймгийн Засаг дарга нь орон нутгийн өмчит ... зуслангийн барилга байгууламж, өмч хөрөнгийг гэрээний хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаанд эзэмшүүлэхээр чанар байдлын одоогийн түвшинг тодорхойлон 2003 оны тайлан тэнцэлд тусгагдсан бүртгэлийн үнээр хүлээлгэн өгч эзэмшүүлнэ.”* гэж заасан боловч 2003 оны тайлан, хөрөнгө хүлээлцсэн актыг мөн л архивлаагүй байна.

2.2.4 Хүүхдийн зуслангуудыг хувьчлахаар шийдвэрлэсэн аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоолд дурдагдсан дансны анхны үнэ нь:

- Гүннуур зуслангийн 2008 оны төрийн болон орон нутгийн өмчийн тооллого, дахин үнэлгээтэй тохирч байна.
- Арцат зуслангийн 2008 оны төрийн болон орон нутгийн өмчийн тооллого, дахин үнэлгээний баримт, материал архивлагдаагүйгээс “Менежментийн гэрээ”-гээр ажиллахаар шийдвэрлэсэн үеийн буюу 2002 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж үзэхэд тохирч байна.

2.2.5 Хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага Мон үнэлгээ ХХК нь Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн захиалгаар 2010 оны 06 дугаар сард тус 2 зуслангийн барилгуудыг дахин тооллого, хэмжилт хийж, зориулалт, хийцийн ангилал, инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлыг тогтоож үнэлгээ хийсэн байна.

1. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана;

1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;

2. Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг Төрийн өмчийн хороо эрхлэн 4 жилд 1 удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан явуулна.

2.2.6 Мон үнэлгээ ХХК нь барилгын дахин үнэлгээг өртгийн хандлагаар Сангийн сайдын 2009 оны 135-р тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”-ийг баримталж дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

Хүснэгт 2: Мон үнэлгээ ХХК-ийн тогтоосон үнэлгээ /мянган төгрөг/

Хүүхдийн зуслангийн нэр	Барилга байгууламжийн нэр, тоо	Ашиглалтад орсон огноо	Ашигласан хугацаа	Орлуулалтын өртөг	Элэгдлийн зардал	Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг буюу дахин үнэлсэн дүн	Мон үнэлгээ ХХК-ийн тогтоосон үнэлгээ
Арцат зуслан	Үлгэрийн байшин, гэр хэлбэрт байшин, хүүхдийн байр, хоолны заал г.м 44 байр	1983	27	100,433.2	64,846.7	35,586.5	35,580.0
Гүннуур зуслан	Конторын барилга, Соёлын төв, амрагчдын байр, багш нарын байр г.м 41 байр	1979	31	156,035.1	106,897.6	49,137.5	49,140.0

Эх сурвалж: Мон үнэлгээ ХХК-ийн үнэлгээний тайлан

2.2.7 Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Арцат, Гүннуур зусланг хувьчлах үнийг Мон үнэлгээ ХХК-ийн үнэлгээний дүн болон бусад хөрөнгийн нийлбэр дүнгээр тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3: ИТХТ-ийн тогтоол /мянган төгрөг/

Байгууллага, аж ахуйн нэр	Үндсэн хөрөнгийн нэр /тоо ширхэг/	Ашиглалтад орсон он	Дансны анхны үнэ	Дахин үнэлгээний үнэ /2008 он/	Мон үнэлгээ ХХК-ийн шинэчлэн тогтоосон бодит үнэ	Бусад хөрөнгө	ИТХТ-ийн шийдвэр
Гүннуур зуслан	Зуны байр 41 ширхэг	1979	63,301.6	156,786.9	49,140.0	8,916.4	58,056.4
Арцат зуслан	Зуны байр 44 ширхэг	1983	4,158.7	41,587.0	35,580.0	11,951.8	47,531.8

Эх сурвалж: Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоол

2.2.8 Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 90 дүгээр тогтоолын дагуу Гүннуур зусланг 58,056.4 мянган төгрөгөөр, Арцат зусланг 47,531.8 мянган төгрөгөөр тус тус худалдаж, төлбөрийг Зоос банкин дахь Аймаг хөгжүүлэх сангийн 2404334850 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 4: Зуслангийн хувьчлалын төлбөр /мянган төгрөг/

Хүүхдийн зуслангийн нэр	10 сар	11 сар	12 сар	Нийт дүн
Арцат зуслан	30,000.0	17,531.8		47,531.8
Гүннуур зуслан	30,056.4	10,000.0	18,000.0	58,056.4

Эх сурвалж: Зоос банкин дахь Аймаг хөгжүүлэх сангийн 2404334850 тоот дансны хуулга

Бүлэг III

Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг нь тооцсон эсэх?

Хүүхдийн зуслангуудыг хувьчилсан шийдвэр болон “Худалдах, худалдан авах гэрээ”-ний биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцоогүй байна.

3.1 Хувьчилсан шийдвэр, гэрээгээр хүлээсэн үүргээ оролцогч талууд хэрэгжүүлсэн эсэх?

“Менежментийн гэрээ” болон “Худалдах, худалдан авах гэрээ”-ний оролцогч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан *“Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”*-ийн дагуу хүүхдийн зуслангуудад өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх дараах гэрээнүүдийг байгуулан ажилласан талаар тайлангийн 1.1 дүгээр хэсэгт тодорхой дурдсан билээ. Үүнд:

- 2003 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Хэрх тосгоны сургуулийн харьяа Арцат, аймгийн Хүүхдийн төлөө төвийн харьяа Гүннуур хүүхдийн зуслангуудыг хувьчлагдаж дуустал “Аж ахуйн тооцоон дээр ажиллуулах гэрээ”,
- 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүүхдийн зуслангуудыг “Менежментийн гэрээ”-гээр 2007 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаатай ажиллуулах гэрээ,
- 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Худалдах худалдан авах гэрээ”-гээр Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг худалдаж, уг гэрээ нь 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл хүчинтэй байхаар тусгасан.

3.1.2 Менежментийн багууд нь *“Менежментийн гэрээ”*-ний дагуу хүүхдийн зуслангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулан, 2010 оны тайланд дараах байдлаар тайлагнасан байна.

- Арцат зуслан нь жил бүр 2 сарын хугацаанд хүчин чадлыг бууруулахгүйгээр тасралтгүй ажиллаж, нийт 2500 гаруй хүүхдийг хүлээн авч амруулан, 16-20 тогтмол ажлын байрыг бий болгож, 61.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
- Гүннуур зуслан нь жил бүр 6 ээлжээр нийт 2291 хүүхдийг хүлээн авч амруулан, нэг ээлжид 8 хүнийг ажлын байраар ханган ажиллуулж, нийт 84.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, урсгал засвар хийсэн гэх мэт.

3.1.3 Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2010 онд байгуулагдсан ажлын хэсэг нь менежментийн багууд 2004 онд байгуулсан *“Менежментийн гэрээ”*-ний дагуу жил бүр зуслангийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээ тайланг аймгийн ЗДТГ болон төрийн холбогдох бусад байгууллагуудад гарган өгч байгаагүй гэж дурдсан боловч ерөнхийдөө *“Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн гэж үзээд зуслангуудыг менежментийн багт хувьчлан өгөх боломжтой”* гэж дүгнэсэн байна.

3.1.4 Бид аудитын явцад аймгийн ИТХ-аас тодруулга авч, хүүхдийн зуслангуудыг хувьчлан авсан эрх бүхий хүмүүстэй асуулга, ярилцлага хийх явцад дараах нөхцөл байдал илэрлээ. Үүнд:

- Арцат хүүхдийн зусланг “Менежментийн гэрээ”-гээр ажиллуулж байх явцад буюу 2009 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн аймгийн ИТХТ-ийн “Замын тэнхлэгийн шугам, карьерын байршил тогтоох тухай” 74 дүгээр тогтоолоор “Гацууртын уурхай хүртэл сайжруулсан хайрган зам тавихыг зөвшөөрч, замын тэнхлэгийн шугам дайрах цэг, замд ашиглах хайрга чулууны карьерын байршил”-ыг тус тус тогтоосон байна.
- Уг байршилд Арцат зуслангийн эзэмшлийн газар багтсан гэх үндэслэлээр гэрээлэгч нь гэрээлүүлэгч талд мэдэгдэж, тохиролцолгүйгээр зусланг ашиглах эрхийг Бороо Гоулд компанид шилжүүлж, Мандал сумын Тултын тохой гэдэг газар 170 хүүхдийн багтаамжтай шинэ хүүхдийн зусланг байгуулсан байна.

3.1.5 Ингэснээр Арцат зусланг худалдан авсан тал шинээр байгуулагдсан Тултын тохой хэмээх газар байрлах хүүхдийн зусланг эрхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд албан ёсоор хувьчилсан Мандал сумын Арцатын аманд байрлах Арцат зуслан нь үйл ажиллагаа явуулаагүй байна.



/Тултын тохой хэмээх газар байрлах хүүхдийн зуслан/

3.1.6 Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг хувьчилж, худалдсан 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ”-г 2016 оны 01 дүгээр сарын 11 хүртэл 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар тусгаж, гэрээлэгч, гэрээлүүлэгч талын эрх үүрэгт дараах нөхцөлүүдийг тусгасан боловч хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- **Гэрээлэгч талын эрх, үүргийн 7-д** “Арцат зусланг тус гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд үндсэн зориулалтаар ашиглаж.....”, **8-д:** “Гэрээгээр ашиглаж буй хүүхдийн зуслангийн барилга, байгууламж, бусад эд хөрөнгийг бусдад дамжуулан түрээслэх, худалдах тохиолдолд гэрээлүүлэгч талд урьдчилан мэдэгдэж, тохиролцсон байх үүрэгтэй”.
- **Гэрээлүүлэгч талын эрх, үүргийн 5-д:** “Гэрээлэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахгүй байгаа тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ хангаж ажиллах тухай шаардлага тавих эрхтэй”, **8-д:** “Гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах эрхтэй”,

3.1.7 Хувьчилж авсан Гүннуур, шинээр байгуулсан Тултын тохой хүүхдийн зуслангууд нь тогтмол үйл ажиллагаа явуулж байгаад Ковид 19 өвчний улмаас үйл

ажиллагаа нь зогсонги байдалд орсноор өнөөгийн байдлаар хүүхдийн зуслангийн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй байна.

3.1.8 Аудитын явцаас харахад хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавигдах стандарт, шаардлага, зардал өндөр боловч эрхийн бичгийн үнийг багаар тогтоодгоос ашгийн төлөөх хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд алдагдал хүлээх магадлал их, үйл ажиллагаа нь тогтворждоггүй нөхцөл байдал ажиглагдаж байна.

3.2 Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг тухай бүр дүгнэж, холбогдох байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн эсэх ?

Хүүхдийн зуслангийн удирдлагуудтай байгуулсан гэрээний биелэлтэд тухай бүр хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.2.1 Арцат, Гүннуур зуслангийн удирдлагуудтай 2003 онд байгуулсан “Аж ахуйн тооцоон дээр ажиллах гэрээ” болон 2004 онд байгуулсан “Менежментийн гэрээ”-ний биелэлтийг холбогдох байгууллагуудаас тухай бүр дүгнэж, хяналт хэрэгжүүлсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Аж ахуйн тооцоон дээр ажиллах гэрээ”-нд гэрээний биелэлтийг тооцох, хяналт шалгалт хийх асуудлыг тусгаагүй, хэрэгжилтэд хяналт шалгалт хийгээгүй,
- “Менежментийн гэрээ”-ний 5.1-д “Аймгийн Засаг дарга аудитыг сонгож зуслангийн тайланд жилд 1 удаа, мөн гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө тус тус аудитыг хийлгэнэ. Аудит нь гэрээний үүргээ биелүүлж байгаа эсэх, гэрээнд заасан түвшинд хүрсэн эсэх, өмчийн эзэмшилт, ашиглалтын талаар дүгнэлт гаргах бөгөөд аудитын дүгнэлт нь гэрээг дахин сунгах, цуцлах үндэслэл болно” гэж заасан боловч гэрээний хүчинтэй хугацаанд аудит хийлгэж, дүгнэлт гаргаагүй,
- Мөн гэрээний 9.1-д “Талууд гэрээг жил бүрийн эцэст дүгнэнэ” гэж заасан боловч гэрээг жил бүр дүгнээгүй, гэрээний хугацаа 2007 онд дууссан байхад хугацааг сунгаагүй байна.

3.2.2 Харин хүүхдийн зуслангуудыг хувьчилж, худалдахаас өмнө буюу “Менежментийн гэрээ”-ний хүчинтэй хугацаа дууссанаас 3 жилийн дараа аймгийн Засаг даргын 2010 оны 106 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь Арцат, Гүннуур зуслангийн “Менежментийн гэрээ”-г дүгнэж, “Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн гэж үзээд зуслангуудыг менежментийн багт хувьчлан өгөх боломжтой” гэж дүгнэсэн байна.

3.2.3 Ажлын хэсэг зуслангийн хөрөнгүүдийг газар дээр нь очиж, санхүүгийн тайлан, холбогдох бусад материалтай нь тулган шалгасан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тулгалтын дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5: Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тулгалт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Арцат зуслан		Гүннуур зуслан	
	2004 он	2009 он дахин үнэлгээ	2004 он	2009 он дахин үнэлгээ

Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл

Барилга байшин	4,158.7	41,587.0	91,071.2	156,787.0
Тоног төхөөрөмж	2,458.6	24,586.0		
Автомашин	5,500.0	5,500.0		
Нийт үндсэн хөрөнгө	12,117.3	71,673.0	91,071.2	156,787.0
Эргэлтийн хөрөнгө	3,993.7	39,937.0	1,486.9	8,916.4
Нийт хөрөнгийн дүн	16,111.0	111,610.0	92,558.1	165,703.4

Эх сурвалж: “Менежментийн гэрээний биелэлтийг үнэлэх” ажлын хэсгийн тайлан

3.2.4 2011 онд байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ”-нд гэрээлүүлэгч буюу аймгийн ЗДТГ нь гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, гэрээлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй гэж заасан боловч гэрээ хүчинтэй байхаар заасан 2016 оны 1 сар хүртэл хэрэгжилтэд огт хяналт тавиагүй, биелэлтийг тооцоогүй байна.

3.2.5 Өөрөөр хэлбэл орон нутгийн өмчийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих эрх бүхийн байгууллагууд нь Арцат, Гүннуур хүүхдийн зуслангийн хувьчлал, гэрээний үүргийн биелэлтэд хяналт шалгалт огт хийгээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүүхдийн зуслангуудын удирдах үйл ажиллагааг “Удирдлагын гэрээ”-гээр бус “Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах арга”-ын “Менежментийн гэрээ”-гээр гүйцэтгүүлсэн нь УИХ, Засгийн газар, аймгийн ИТХТ-ийн шийдвэрүүдийг зөрчсөн байна.
- Мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн Арцат, Гүннуур зусланг хувьчлах, худалдах доод үнийг тогтоосон байна.
- Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хорооны зохих шийдвэргүйгээр буюу зөвшилцөлгүйгээр худалдах шийдвэр гаргасан байна.
- Уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу нээлттэй зохион байгуулаагүй байна.
- Хүүхдийн зуслангийн барилга, байгууламжийн зах зээлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.
- “Менежментийн гэрээ” болон “Худалдах, худалдан авах гэрээ”-ний оролцогч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Хүүхдийн зуслангийн удирдлагуудтай байгуулсан гэрээний биелэлтэд тухай бүр хяналт хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа-д:

- Хүүхдийн зуслангуудыг Төрийн өмчийн хороотой зөвшилцөлгүйгээр болон уралдаант шалгаруулалтыг хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулалгүйгээр харьяалж байсан байгууллагын дарга, удирдлагуудын хамаарал бүхий этгээдүүдэд хувьчилсан шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг судалж, шийдвэрлэх.
- Арцат хүүхдийн зусланг гэрээлэгч нь гэрээлүүлэгч талд мэдэгдэж, зөвшилцөлгүйгээр ашиглах эрхийг Бороо Гоулд компанид шилжүүлж, Мандал сумын Тултын тохой гэдэг газар 170 хүүхдийн багтаамжтай шинэ хүүхдийн зусланг байгуулсан асуудлыг хянаж, шалгаж, дүгнэлт өгөх.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж- д:

- 2011 онд хувьчлагдсан Арцат, Гүннуур хүүхдийн зуслангууд нь үндсэн зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт, шалгалт хийж, нөхцөл байдлыг тодорхойлох.
- Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байсан Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудын үйл ажиллагааг сэргээн явуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ц.ОТГОНБАЯР
Ж.ЦОГТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС
ИРҮҮЛСЭН САНАЛ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

43080 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2274, 7036-3966

2023. 11. 10 № 292
танай 2023. 11. 01 ны № 130 -т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

ДАРГА



Б.НАРАНТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлангийн төсөлд холбогдох байгууллагаас тайланд өөрчлөлт оруулах санал ирүүлээгүй тул аудитын тайланд өөрчлөлт оруулахгүйгээр шийдвэрлэв.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 21/19

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж) нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж) нарт зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА

018010037

C:\Users\Bichig hereg\Tushaal 2023.docx